

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН
/2022.09.22 - 2022.09.23/

2022.09.23

Дархан-Уул аймаг

№	Ажлын чиглэл	Үйл ажиллагааны гүйцэтгэл
Барилга хот байгуулалтын хэлтэс		
1	Барилгын үйлдвэрлэлийн чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Засгийн газрын 212-р тогтоолын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг 3 удаа зохион байгуулж ажилласан. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Дархан сум, 31-р хорооллын гадна цэвэр ус, бохир, цахилгаан хашаажуулалтыг ажил - Дархан сумын 1,4,7,12,16-р багуудад Япон улсын буцалтгүй тусламжаар хийгдсэн 9206-МОН төслийн 5 ширхэг контейнер тохижуулж суурилуулалтын ажил - Хонгор сумын 2-р багт “Монрок” ХХК-ний гадна цахилгаан шугамын ажил ✓ “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ний Дархан-Уул аймгийн газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу Орхон суманд баригдах 25 метр антенн цамхагийн барилгад барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг хянаж үзэхэд зураг төслөө магадлалаар оруулаагүй байсан тул зөвшөөрөл олгох боломжгүй тухай албан бичгийг хүргүүлсэн ✓ “Дархан дуулга” ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу Дархан сумын 11-р багт байрлалтай 12-р байрыг ашиглалтад оруулсан тухай тодорхойлолтыг албан бичгээр өгсөн. ✓ Барилга, хот байгуулалтын яамнаас зохион байгуулж байгаа шилдэг барилга байгууламжийг шалгаруулах ажлын хүрээнд Дархан-Уул аймагт хийгдсэн шинэлэг өнгө үзэмжтэй, дотор зохион байгуулалт сайтай барилгуудын мэдээллийг хүргүүлсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Твин парк хотхоны 54 айлын орон сууц - Буудай центрийн үйлчилгээний барилга - Шинэ алхам 620 хүүхдийн сургуулийн барилга
2	Барилгын үйлдвэрлэлийн чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ 2022.08.15-19-ний хооронд Барилгын хөгжлийн төвийн дэргэд дэх Барилгын материалын сорил шинжилгээний төв лабораторит 5 хоног тоног төхөөрөмж дээр дадлага хийсэн. Цаашид орон нутаг бетоны сорьц шинжилгээг хийх боломжтой юм. ✓ 2022.08.25 Дархан хөөсөнцөрийн үйлдвэр дээр очиж зохих бичиг баримтыг үзэж шалгах, газар дээр ерөнхий технологич байхгүй тул холбогдох баримт бичигтэй ирж уулзахыг зөвлөж үйлдвэрлэлийг цаашид үргэлжлүүлэх бол шинжилгээний бичиг, зөвшөөрөл авахыг тайлбарласан
2	Инженерийн дэд бүтэц	<ul style="list-style-type: none"> ✓ Дархан сумын 7-р баг 1-р сургуулийн урд талаар хийхээр төлөвлөж буй авто замын газар чөлөөлөлтөд явж иргэдтэй тохиролцсон. ✓ Дархан сумын 7-р багийг 31-р хороололтой холбох авто замын ажилд ирган Энхбаяртай газар чөлөөлөх талаар уулзаж саналыг авсан. ✓ Дархан сумын 10-р баг 12-р хороололд байрлах Мөнх болор эрдэнэ ХХК архитектор төлөвлөлтийн даалгаварын хүсэлтийг авч шийдвэрлэсэн. ✓ Хонгор сумын 1-р багт баригдаж буй Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт ТӨХХК-ний инженерийн шугам сүлжээний зурваст орсон аж ахуй нэгжлийн судалгааг гаргаж албан тоотоор хүргүүлсэн. ✓ Дархан суманд 2023 онд хийгдэх Хөгжлийн хөтөч гүйцэтгэж буй авто замын зураг төсөлд шаардлагатай газар олголтын захирамжийн төслийг боловсруулж ХБТХОХ-т хүргүүлсэн. ✓ Дархан-Уул аймгийн хэмжээнд хэрэгжиж буй зам, барилга угсралтын бүтээн байгуулалтын хуралд оролцсон. ✓ Засгийн газрын 213-р тогтоолын дагуу барилга ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 3 барилгад олгосон. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Цахир түмэн алтай ХХК-ний Шарын гол сумын дулааны шугамын өргөтгөлийн ажил - Өгөөмөр баян булаг ХХК-ний цэвэр усны шинэчлэлтийн ажил

		<ul style="list-style-type: none"> ✓ - ДСЦТС ХК жимс дэд станцын шинэчлэлтийн ажил 																		
Газрын удирдлагын хэлтэс																				
1	Суурь судалгаа газрын мониторинг	<p>/2022.09.19-09.23/</p> <ol style="list-style-type: none"> 1. Захиалгат хянан баталгааны 3 тайлан баталгаажуулж 2 тайлан хянаж буцаасан. 2. Нөхөн бүрдүүлэлтийн ажлын хүрээнд анхны өмчлөгчийн мэдээллийн дагуу мэдээллийн санд өргөдөл үүсгэж ажиллав. 3. Шинээр хянан баталгааны зөвшөөрөл авч ажлаа эхлүүлж байгаа Гео инженер сүрвэй ХХК-д аргачилсан зааврын дагуу зөвлөгөө өгч ажилласан. 4. 2 иргэний цахим гэрээ гэрчилгээг үүсгэж мэдээллийн санд нөхөн бүрдүүлэлт хийсэн. 5. Аймгийн Засаг даргын захирамжаар газрын эрх шилжсэн иргэдийн гэрээг үүсгэж, иргэдэд утсаар мэдэгдэв. 																		
2	Газрын кадастрын чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц , гараж, барилга байгууламж, хуваалт / тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагуудаар хэмжилт хийлгэсэн 6 иргэний материалыг хүлээн авч мэдээллийн санд оруулж кадастрын зураг гаргасан. ✓ Өмчлөлийн газраа худалдах, өвлүүлэх, бэлэглэх гэрээгээр шилжүүлж байгаа нийт 10 иргэний цахим хүсэлтийг мэдээллийн санд өөрчлөлт хийж, кадастрын зургийг гаргаж өгсөн. ✓ Шинэчилсэн бүртгэлд орох шаардлагатай 14 нэгж талбарын нөхөн бүрдүүлэлтийг хийсэн. ✓ Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дэргэдэх Газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх хуралдаас хасагдсан 5 иргэнд хариу мэдэгдэл хүргүүлсэн ✓ Сумын Засаг даргад Захирамжийн төсөл бэлдэж хүргүүлсэн. 																		
3	Геодези, зураг зүйн чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Хаягийн зургийн дагуу 6 иргэн, 2 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон. ✓ Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц , гараж, барилга байгууламж, хуваалт / хэмжилт хийлгэсэн 7 иргэн, 1 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч мэдээллийн санд оруулж кадастрын зураг гаргасан. ✓ Геодези, зураг зүй, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Гео од”, “Ёлт сүрвэй” ХХК-ний хийж гүйцэтгэсэн барилга байгууламж, зам, талбай, инженерийн шугам сүлжээний 2 улаан шугам, 4 гүйцэтгэлийн зургийг хүлээж авсан. ✓ Тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн хийсэн инженерийн шугам сүлжээний гүйцэтгэлийн зургийн материалыг нэгтгэн тайланг Able-ээр ГЗБГЗЗГ-ын ГУХ-ын мэргэжилтэн Г.Энхзаяад хүргүүлсэн. 																		
4	Газрын төлбөрийн чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Аймгийн Татварын хэлтэст 2020, 2021 оны хүлээгдэж буй нэхэмжлэлийн жагсаалтыг 2022.09.06-ний өдрийн байдлаар гаргаж darkhan@mta.gov.mn хаягаар явуулсан. <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <thead> <tr> <th>Сумын нэр</th> <th>2020</th> <th>2021</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Дархан</td> <td>218,508,287</td> <td>414,930,598</td> </tr> <tr> <td>Орхон</td> <td>2,544,726</td> <td>5,230,178</td> </tr> <tr> <td>Хонгор</td> <td>36,714,284</td> <td>95,430,726</td> </tr> <tr> <td>Шарын гол</td> <td>5,414,951</td> <td>6,419,851</td> </tr> <tr> <td>Нийт</td> <td>263,184,268</td> <td>522,013,374</td> </tr> </tbody> </table>	Сумын нэр	2020	2021	Дархан	218,508,287	414,930,598	Орхон	2,544,726	5,230,178	Хонгор	36,714,284	95,430,726	Шарын гол	5,414,951	6,419,851	Нийт	263,184,268	522,013,374
Сумын нэр	2020	2021																		
Дархан	218,508,287	414,930,598																		
Орхон	2,544,726	5,230,178																		
Хонгор	36,714,284	95,430,726																		
Шарын гол	5,414,951	6,419,851																		
Нийт	263,184,268	522,013,374																		

		<ul style="list-style-type: none"> ✓ Төрийн албаны шалгалт ирэхтэй холбоотой ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж, 4 төрийн албан хаагчийн хувийн хэрэгт үзлэг хийж, дутуу баримт бичгийг 2022.09.26-ний өдрийн дотор бүрдүүлэх жагсаалт гаргаж өгсөн.
Захиргаа аж ахуйн чиглэл		
1	Захиргаа, хууль эрх зүй	<ul style="list-style-type: none"> ✓ Төрийн албаны зөвлөлөөс “Хүний нөөцийн аудит хийх удирдамж”-ын хүрээнд “Чадахуйн зарчмын хэрэгжилт”-ийг хангах зорилтын дагуу 2019-2022 оны эхний хагас жилийн хүний нөөцийн аудитад бэлтгэх, шаардлагатай мэдээллийг боловсруулах үүднээс төлөвлөгөөг батлуулж, газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн тушаалаар Ажлын хэсгийг байгуулж, Газрын удирдлагын хэлтсийн даргаар ахлуулж ажиллаж байна. ✓ “Авилгатай тэмцэх газрын ажлын хэсгийн орон нутагт ажиллах удирдамж”-ын дагуу ЭБАТ-аас албан хаагчдын ХАСУМ, ХАСХОМэдүүлсэн талаар бэлтгэл хангах, танилцуулга боловсруулж 2022 оны 09 дүгээр сарын 23-ны №604 тоотойр Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэсд хүргүүлсэн. ✓ Нийт албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг хангуулж, баяжилтын ажлыг зохион байгуулж ажиллаж байна.
2	Мэдээллийн технологи, нярав	<p>Мэдээлэл: 70376471 нээлттэй утсаар 0 иргэн /Нүүж өөр өрөөнд орсон тул утасны үзүүр орж ирээгүй тул/, байгууллагын Facebook хуудсанд ирсэн 9 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв. 2022-09-20-нд цахим төвд ажиллав. Өөрийн болон үйлчлэгчийн хувийн хэргийн бүрдлийг шалгаж, дутуу бичиг баримтыг нөхөн хийв.</p> <p>Мэдээллийн технологи: Орхон сумын 2018, 2020, 2022 оны бэлчээрийн фотомониторингийн харьцуулсан зургийн эх бэлтгэв. Шарын гол сумын газрын даамлын компьютерт *.kmz өргөтгөлтэй файлыг нээж үзэх боломжтой Google Earth програмыг суулгаж, Хонгор сумын газрын даамлын сканерийн програм гэмтсэн тул засварлаж өгөв.</p> <p>Нярав: 20 ширхэг Нэгж талбарын хувийн хэрэг нугалж мэргэжилтнүүдэд олгоход бэлтгэв. Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 13 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгож, кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 20 ширхэгийг хүлээж авч бүртгэв.</p>

Тайлан боловсруулсан:
Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Хянасан:
Газрын удирдлагын хэлтсийн дарга

Б.Золбаясах
Г.Нямдорж